

122



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2021 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 8/94

Ховд

**Ц.Оюунчимэгийг ахлах мэргэжилтнээр  
томилох тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4, 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг нь Авлигатай тэмцэх газрын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 05/12930 тоот албан бичгээр хянагдаж ирсэн Ц.Оюунчимэгийг 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн ахлах мэргэжилтнээр жинхлэн томилсугай.

2. Ц.Оюунчимэгийг Төрийн захиргааны албан тушаалын ТЗ-6-4 дэх шатлал буюу 813215 төгрөг (найман зуун арван гурван мянга хоёр зуун арван тав)-өөр цалинжуулж, холбогдох нэмэгдлүүдийг журмын дагуу бодож олгохыг Санхүү, аж ахуйн тасгийн ерөнхий нягтлан бодогч (Б.Нямдэлгэр)-д зөвшөөрсүгэй.

3. Нийтийн албан болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилэн сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдол бүрт тайлбар, мэдүүлэг гаргаж ажиллахыг /Ц.Оюунчимэг/-т даалгасугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД